

ХЭНТИЙ АЙМГИЙН ЭМНД-ЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БАЯРМАА ТАНАА



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2018-04-12 № 06/150

танай _____ -ны № _____ -т

Г

Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Аймгийн ЭМНД-ын хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт,

түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын код: ХЭА- /2018/ 23 / СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Хэнтий аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: Khentii @audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 70562147 Цахим хаяг:

Ахлах аудитор Б.Наранцэцэг

Утас: 70562147 Цахим хаяг: Narantsetsegb@audit.gov.mn

Чингис хот

Агуулга	
2.1	Оршил 2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага 2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт 3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин 3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ 4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал 4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар 5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн 5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл 5
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал 6
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал 6
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал 6
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал 6
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал 6
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга 6
2.12	Шилэн дансны мэдээлэл 7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга 7
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл 7
3.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл 9
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 9
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 9
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 9
3.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 9

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг ЭМНДХ-ийн дарга Ц.Баярмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудит хийсэн санхүүгийн тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аймгийн НД-ын сангийн 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, НД-ын хэлтсийн үйл ажиллагааны тайланг түүвэрт хамруулж аудит хийсэн байна.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит /ХЭА-2018/ 23 /СТА-ТТЗ / хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

ЭМНД-ын хэлтэс нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дугаар сарын 11-нээс 2018 оны 4 дугаар сарын 13-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 13-нд эцэслэн баталгаажуулж, аймгийн

ЭМНД-ын хэлтсийн даргад хүргүүлэхээр төлөвлөн, аймаг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Наранцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн ЭМНД-ын хэлтсийн даргын 2018 оны 04 дугаар сарын 11-ний өдрийн 2\174 тоот албан бичгээр Аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Шилэн дансны тухай, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйл-д “Нийгмийн даатгалын байгууллага өөрийгөө санхүүжүүлэх, нийгмийн даатгалын байцаагч хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, даатгуулагч, ажил олгогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах зарчим баримтална” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, зорилтыг тодорхойлсон байна.

ЭМНД-ын хэлтэс нь “ Бид даатгуулагчдынхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

ЭМНД-ын хэлтэс нь нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 110 хувиар биелүүлж, 19154.8 сая төгрөг хуримтлуулсан байна.

Арилжааны ХААН, Төрийн, Хас, Капитал банкуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ЭМНДЕГ-ын даргаар батлуулан ажиллаж байна.

Тайлант онд 9889 тэтгэвэр авагчдад 32165.6 сая төгрөгийн тэтгэвэр, 3667 даатгуулагчдад 1561.2 сая төгрөгийн тэтгэмж, 722 даатгуулагчдад 2423.6 сая төгрөгийн ҮОМШӨ-ний тэтгэвэр тэтгэмж, 390 даатгуулагчдад 560.6 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгожээ.

ЭМНД-ын хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

ЭМНД-ын хэлтсийн удирдлага дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ЭМНД-ын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан НДЕГ-ын даргын тушаалаар батлуулан 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандартай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ЭМНД-ын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Пластик” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл ойлголтод үндэслэн эрсдлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн аудитын 5 эрсдэл тодорхойлон, тэдгээрийг ТБ-СТА-Б-2.2 маягтад нэгтгэж баримтжуулав.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 15 буюу дунд эрсдэлтэй байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл дунд буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 4 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 65429.0 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 654.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон 5 эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 5 эрсдэлтэй асуудалд батламж мэдэгдлүүдийн хүрээнд 5 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитын хүрээнд нийгмийн даатгалын сангийн тайланд итгэл үзүүлж, нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн зардлыг шалгахад 2 ажилтныг ажлаас үндэслэлгүйгээр халж шүүгчийн захирамжаар нийт 4891.5 мянган төгрөгийг байгууллагын цалингийн зардлаас олгож иргэнийг хохиролгүй болгосон ч төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан зөрчил илэрч, илэрсэн зөрчлийг асуудлын бүртгэлд тусган, ЭМНД-ын хэлтсийн удирдлагад танилцуулан баталгаажуулсан болно.

Шийдвэрлэсэн: 1. Төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буюу хэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Өнөрцэцэгээр 4243.3 мянган төгрөгийг, дарга Ц.Баярмаагаар 648.2 мянган төгрөгийг тус тус нөхөн төлүүлэх

2. Цаашид ажлаас халах шийдвэрийг үндэслэлтэй гаргаж зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар 2 зөвлөмж өгсөн.

ЭМНД-ын хэлтсийн дарга 2018.03.09-ны өдрийн 1/110 тоот албан бичгээр менежментийн захидлын хариуг ирүүлэхдээ "..... Хэнтий аймгийн СД-ын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.01.03-ны өдрийн 156\ШШ2017\0012, 1 дүгээр сарын 16-ны өдрийн 156\ШШ2016700031 дугаартай шүүгчийн захирамжийг үндэслэн 2 ажилтны цалинг ЭМНДХ-ээс нөхөн гаргаж олго гэсэн шийдвэрийн дагуу байгууллагын цалингийн зардлаас олгосон тул аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрөхгүй байна." гэсэн болно.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүрээнд төлбөрийн акт тогтоох асуудал гараагүй. Харин нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 4891.5 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх зөвлөмж өгөхөд хүлээн зөвшөөрөөгүй байна.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэх алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ЭМНД-ын хэлтсийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 42127.5 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 41602.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/ сая төгрөгөөр/

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	42127,5	41602,4	99	525,1
1.1	Урсгал зардал	42127,5	41602,4	99	525,1
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0	0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0	0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	42127,5	41602,4	99	525,1
2.1	Улсын төсвөөс санхүүжих	0	0	0	0
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	42127,5	41451,0	96,68	676,5
2.3	Туслах үйл ажиллагааны орлогоос	0	676,5	0	-676,5
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	0	0	0	0
2.5	Бусад эх үүсвэр	0	0	0	0

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд урсгал зардал 525.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

ЭМНД-ын хэлтэс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг "shiiendans.gov.mn" цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны эхний 10 сарын байдлаар нийцлийн аудит хийхэд ЭМНД-ын хэлтэстэй холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

2.13 ӨМНӨХ зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх онд Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийгдээгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн гэж үзэж зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.9-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад төсвийн зарцуулалттай холбоотой 4.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон байна. Иймд аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

Огноо: 2018.04.13

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

Огноо: 2018.04.12

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



Б.НАРАНЦЭЦЭГ

Огноо: 2018.04

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

3.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газар

ХЭНТИЙ АЙМГИЙН ЭМ,НД-ЫН ХЭЛТСИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Цалингийн зардлын талаар3

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн ЭМ,НД-ын хэлтсийн дарга, нягтлан бодогч нарт талархал илэрхийлье.

ажиглалт

АГ-ын зөвлөмж

Цалингийн зардлын зарцуулалтыг шалгахад... нийт 4891.5 мянган... иргэнийг хохиролгүй болгосон ч төрд... хохирлыг гэм буруутай албан... буцааж төлүүлээгүй, төсвийн... үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан... тухай хуулийн 6.4.1 дэх заалттай... байна.

- 1. Төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буюу хэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Өнөрцэцэгээр 4243.3 мянган төгрөгийг, дарга Ц.Баярмаагаар 648.2 мянган төгрөгийн нөхөн төлүүлэх
- 2. Цаашид ажлаас халах шийдвэрийг үндэслэлтэй гаргаж зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах

Эрсдэлүүд

Төсвийн захирагчийн хариу

Хууль тогтоомжийг мөрдөхгүй

Зөвлөмжийн биелэлтийг 2018.12.15-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт бичгээр ирүүлнэ үү.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ


НАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ШТЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Б.НАРАНЦЭЦЭГ

Огноо: 2018.02.28

АГ-ын ажиглалт

1.Цалингийн зардлын зарцуулалтыг шалгахад
2.ажилтныг ажлаас үндэслэлгүйгээр халж шүүгчийн захирамжаар нийт 4891.5 мянган төгрөгийг байгууллагын цалингийн зардлаас олгож иргэнийг хохиролгүй болгосон ч төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дах заалттай нийцэхгүй байна.

АГ-ын зөвлөмж

1.Төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буюу хэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Өнөрцэцэгээр 4243.3 мянган төгрөгийг, дарга Ц.Баярмаагаар 648.2 мянган төгрөгийн нөхөн төлүүлэх
2. Цаашид ажлаас халах шийдвэрийг үндэслэлтэй гаргаж зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх


Төсвийн захирагчийн хариу

*Шүүгчийн захирамжийг гаргуу
Ламсатан цаашаа Нийгмийн
салтаны хэргийг нөхөн гаргах
сво хэргийг гаргуу байгууллагын
цахимын зургаад гаргасан Д.Х.*

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ЭРДЭНЭБААТАР
Д.ОЮУНТУЯА
Б.НАРАНЦЭЦЭГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Огноо: 2018.02.28